БАТЛАВ
"АЛТАЙ-УЛИАСТАЙН ЭРЧИМ ХҮЧНИЙ СИСТЕМ"
ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ЗАВХАН АЙМАГ ДАХЬ САЛБАРЫН
ДАРГА Г.БАДАМХАТАН

2025 оны.06.дугаар сарын.23.

АУЭХС-ТӨХК

ТЕХНИКИЙН НӨХЦӨЛ

Дугаар 53-02/25

2025 он 06 сар 23 өдөр Улиастай сум

Нэг. Ерөнхий мэдээлэл:

1.1	**Хүсэлтийн дугаар:**	*№200*
1.2	**Хэрэглэгчийн нэр, регистр:**	*Завхан аймаг Тосонцэнгэл сум ЗДТГазар*
1.3	**Хэрэглэгчийн байршил:**	*Завхан аймаг Тосонцэнгэл сум*
1.4	**Ажил үйлчилгээний зориулалт:**	*Тосонцэнгэл сумын дулааны 1,2-р хэлхээ, УДДТ-2*
1.5	**Техникийн нөхцөл олгох үндэслэл:**	*1/ ЗАВХАН АЙМГИЙН ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗАРЫН 2025.06.18-ны №200 тоот албан хүсэлт.* *2/ Завхан аймаг Тосонцэнгэл сумын нийтийн эзэмшлийн газар*
1.6	**Техникийн нөхцөлийн ангилал:**	*Шинэ холболт*
1.7	**Тооцооны бүрэн чадал:**	*140 кВт*

Хоёр. Холболтын цэг:

2.1	*Тосонцэнгэл суманд байрлах 10 кВ-ын Тосон-3 нэртэй ЦДАШ-ын №....-р тулгуурыг төмөр бетон анкер тулгуур болгож салбарлан авч төмөр бетон бүхий тулгуур ЦДКШ, КТПН дэд станц барьж, 0.4кВ-ын ерөнхий щитнээс газар кабелиар холбож авах*

Гурав. Тоолуур, хэмжих хэрэгсэл:

3.1	Хэрэглэгчийн ерөнхий щитний 0,4 кВ талын ерөнхий оруулгад DLMS протоколыг дэмждэг 3-фазын, /5А-ийн/ DTZY-88 болон түүнтэй дүйцэхүйц бүрэн электрон тоолуур,
3.2	"АУЭХС" ТӨХК-д ашигладаг ухаалаг тоолуурын ТАМАДУМ системтэй нийцэж ажилладаг байх. ачаалалд тохирсон автоматыг тусгай хайрцагт суурилуулах.

Дөрөв. Тусгай шаардлага:

4.1	10 кВ-ын Тосон-3 нэртэй ЦДАШ-ын №...-р тулгуураас салбарлаж төмөр бетон тулгуур бүхий анкер тулгуур босгож хуурай салгуураар тоноглож ЦДКШ-аар,холбох, шинээр барих КТПН дэд станцад 250 кВА чадал бүхий трансформатор суурилуулах 0.4кВ-ын ерөний щитнээс газар кабелиар холбож авах.
4.2	Шинээр баригдах КТПН дэд станцаас 10 кВ-ын "Тосон-3" ЦДАШ"-ын №....-р тулгуурлуу стандартын шаардлага хангасан 10 кВ-ын АВВГ маркийн хос кабель утас татаж холбох.
4.3	Шинээр барих 10кВ-ын ЦДАШ-ын эхэнд хуурай салгуур тоноглож тавих.
4.4	Уг салбарлаж байгаа хэсэгт 10кВ-ын шугамын гэмтэл заагч суурилуулах.

4.5	Цахилгаан хангамжийн II зэрэглэлийн шугамнаас холбогдож байгаа тул цахилгаан эрчим хүчний нөөц эх үүсгэвэртэй байх.
4.6	Дэд станцын 0,4кВ-ын щит дотор суурилуулж буй тоноглолууд нь өмнө ашиглагдаж байгаагүй шинэ тоноглол байх, ±10%-ийн хүчдэлийн хэлбэлзэлд хэвийн ажилладаг байх.
4.7	Хэрэглэгчийн ерөнхий щит нь автомат, рубильник, Вольтметр, Амперметр зэргээр тоноглож монтажилах ба цахилгаан хэрэгсэл, тоног төхөөрөмжөө хүчдэлийн хэлбэлзэл, хэт ачаалал, богино залгааны гүйдэл, фаз бүрэн бус үед, хэт хүчдэлээс хамгаалах төхөөрөмж тавьж тоноглолыг хамгаалах.

Тав. Дор дурдсан техникийн даалгавар хууль дүрмийг мөрдөх:

5.1	Энэхүү техникийн нөхцөлийн дагуу тавигдах шугам, тоноглолууд нь "Алтай Улиастайн Эрчим Хүчний Систем" төрийн өмчит хувьцаат компанийн баталсан "Техникийн шаардлагын тодорхойлолт"-ыг хангасан байх шаардлагатай.
5.2	Щитний газардуулга болон шугам тоноглолын хэмжилт, туршилтыг норм, дүрмийн дагуу хийлгэн холбогдох газраар шалгуулж протокол авсан байх.
5.3	"Эрчим хүчний тухай хууль"-ийн 30.1.8-д заасны дагуу өөрийн ашиглалт үйлчилгээний зааг доторхи цахилгаан тоног төхөөрөмжиндөө байнга үзлэг шалгалт хийж хэвийн бус ажиллагаатай үед өөрсдийн хөрөнгөөр засвар үйлчилгээг хийлгэх.
5.4	"Эрчим хүчний тухай" хуулийн 30.1.10-ийн дагуу түгээх, зохицуулалттай, эсхүл зохицуулалтгүй хангах тусгай зөвшөөрөл эзэмшигчийн зөвшөөрлөөр өөрийн эзэмшлийн шугам, тоног төхөөрөмжөөс бусад хэрэглэгчийг холбуулах
5.5	"Эрчим хүчний тухай" 30.1.12.эрчим хүчний шугам сүлжээ, тоног төхөөрөмжид эвдрэл гэмтэл учруулсан бол шаардагдах засварыг өөрөө хариуцах. Хэрэглэгч уг эвдрэл, гэмтлийг засах шаардлагатай арга хэмжээ авахгүй бол хангагч засварыг хийж, гарсан зардлаа хэрэглэгчээс шаардан авах эрхтэй
5.6	Угсралтын ажлын явцад тус компанийн харьяа салбар, алба хэлтэсээр хяналт тавиулж, холбогдох баримтыг бүрдүүлсэн байх.
5.7	Техникийн нөхцөлд тусгагдсан ажлуудыг хийж гүйцэтгэсний дараа "Цахилгаан эрчим хүч хэрэглэх дүрэм"-ийн 4.22, 4.23, 4.24-р заалт, Систем компанийн дотоод журмын заалтын дагуу шугам сүлжээнд холбоно.

Зургаа. Бусад

6.1	Энэхүү техникийн нөхцөлийн дагуу холболтыг 2 жилийн хугацаанд хийж, гүйцэтгэх бөгөөд энэ хугацаанд цахилгаан сүлжээнд холбогдоогүй тохиолдолд шинээр техникийн нөхцөл авна.

БОЛОВСРУУЛСАН:

АХЛАХ ИНЖЕНЕР Б.ЛХАГВАДОРЖ

2025 оны 06 дугаар сарын 23

ТАНИЛЦСАН:

АШИГЛАЛТ ЗАСВАРЫН АЛБАНЫ ДАРГА

БӨГӨӨД ЦАХИЛГААНЫ ИНЖЕНЕР С.МЯГМАРЖАВ

2025 оны.06...дугаар сарын23...

БОРЛУУЛАЛТЫН АЛБАНЫ ДАРГА Л.ДЭЛГЭРМАА

2025 оны.6...дугаар сарын23...